



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2025 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа-2050 Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.2.23 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, код”, “Монгол уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний хүрээ, заавар”-ын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Монгол уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, код”, “Монгол уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний хүрээ, заавар”-ын төслийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан боловсруулж танилцуулахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга (Р.Гантуяа)- д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141250376

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 18 өдрийн 06/1 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Р.Гантуяа, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга

Нарийн бичиг

А.Анхзаяа, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн уламжлалт анагаах ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн дарга

Д.Цэнд-Аюуш, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Уламжлалт анагаах ухаан судлал, Мэргэжлийн салбар зөвлөлийн дарга

Б.Анхбаяр, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Уламжлалт сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгч

Д.Түмэнбаяр, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Монгол уламжлалт эмчилгээний тасгийн эрхлэгч

Н.Энхтүвшин, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэргээн засах эмчилгээний тасгийн зүүний эмч

Д.Шинэтуяа, Уламжлалт анагаах ухааны технологийн хүрээлэнгийн эмнэлгийн дарга

Т.Лхамжав, АШУҮИС-ийн, Монгол Анагаах Ухааны төв эмнэлэг, Чанарын албаны дарга

Т.Одгэрэл, Монг-Эм эмнэлгийн эрүүл мэнд чанар аюулгүй байдлын менежер

Г.Машбат, Монголын нэгдмэл анагаах ухаан нийгэмлэгийн төлөөлөл

Р.Цолмон, Тэжээхүй ухаан төрийн бус байгууллага

Б.Ганчулуун, Хас холбооны нарийн бичгийн дарга

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 28 өдрийн 961 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ӨВЧНИЙ БҮЛЭГ, ОНОШИЙН АНГИЛАЛ, КОД,  
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВРЫГ  
ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

**Үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа-2050 Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.” гэсэн зорилтын 2.2.23-т “Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гаргах гарцыг дэмжин бренд болгоно” гэж заасан байдаг. ЭМС-ын 2022 оны А/55 дугаар “Уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал код шинэчлэн батлах тухай” тушаалд оношийн хамааралтай бүлэг нь хоорондоо хамааралгүй өвчнүүдийг нэг бүлэгт бүлэглэсэн. ЭМС-ын 2019 оны А/378 дугаар “Монгол уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний заавар батлах тухай” тушаалд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний хүрээг архаг болон болон цочмог өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээтэй уялдаагүй байна.

Иймд дээрх тушаалуудыг шинэчилснээр уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, тусламж үйлчилгээний мэдээг бүртгэх, мэдээлэхэд чухал ач холбогдолтой юм.

**Зорилго:**

“Монгол уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, код”, “Монгол уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний хүрээ, заавар”-ын тушаалын төсөл боловсруулах.

**Ажлын хэсгийн үйл ажиллагааны чиглэл, үүрэг**

- Ажлын хэсгийн ахлагч нь ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдсэн ойлголтод хүргэж, тушаалын төслүүдийг боловсруулах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах;
- Нарийн бичиг нь ажлын хэсгийн төлөвлөгөөг гаргах, гишүүдийг шаардлагатай эрхзүйн мэдээллээр хангах, хурал, уулзалт, санал авах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах, тушаалын төслийг боловсруулах;
- Гишүүд төсөл боловсруулахтай холбоотой стандарт, тушаал, заавар, статистик мэдээллийг судалж, хариуцсан үүргээ шуурхай биелүүлэх.

**Хугацаа:**

2025 оны 02 дугаар сараас 2025 оны 2 дугаар улирал

**Үр дүн:**

“Уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, код”-ыг шинэчлэх, “Монголын уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний хүрээ, заавар”-ын тушаалын төсөл боловсруулж холбогдох байгууллагуудаас саналыг авч, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах бэлтгэл ажлыг хангасан байна.

---ooOoo---